


МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2091 оны 04 сарын 20 өдөр

Дугаар № 157


Мандалговь

Сургууль, цэцэрлэг, спорт зал, соёлын төв болон аймгийн Биеийн тамир спортын газрын зал, Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын халаалтыг хаах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1, 1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт Ковид-19 цар тахлын үед Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хэмнэх зорилгоор 15 сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, тусгаарлах байраар ашиглаж буй дотуур байрнаас бусад сургууль, цэцэрлэг, спорт зал, соёлын төв болон аймгийн Биеийн тамир спортын газрын зал, Цэнгэлдэх хүрээлэнгийн халаалтын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх дулаанаар зохицуулалтаар хангах байгууллагуудтай хамтран анхны худаг дээр бүрэн хааж, системийн усыг шавхахыг аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

2. Дээрх байгууллагын халаалтыг хаах ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга (Х.Анхбаяр), Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), төсөвт хэмнэлт гаргасан тайланг гаргаж танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт тус тус үүрэг болгосугай.



481210433